

БАТЛАВ  
ЁС ЗҮЙН ХОРООНЫ АЖЛЫН  
АЛБАН ДАРГА  
Н.ТАНБААТАР

2026 оны 2 дугаар сарын 2 ны өдөр

**НИЙГМИЙН ЁС ЗҮЙ, ЁС СУРТАХУУНЫ ТӨЛӨШИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ  
НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ЦАХИМ БҮТЭЭГДЭХҮҮН БИЙ БОЛГОХ, ТҮГЭЭХ  
АЖЛЫН ДААЛГАВАР**

**Зорилго:** Төрийн албан хаагч эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төр ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий хандлагаар нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх нөлөөллийн үйл ажиллагаанд иргэн, хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагыг татан оролцуулж, мэдээллийг олон нийтэд түгээхэд оршино.

<b>Үндэслэл</b>	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасан нийтлэг шаардлага, хориглох зүйл, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилт 3.2, 4.1.1 дэх заалт.
<b>Судлагдсан байдал</b>	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хийсэн шинжилгээ /2021/, Төрийн албан хаагчийн ёс суртахууны эрх зүйн зохицуулалтад хийсэн шинжилгээ /2023/, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан /2025/, Төрийн албан дахь ёс зүйн зөрчил: иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгаа /2025/ Ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тогтоох судалгааны удирдамж /2025/
<b>Хамрах хүрээ</b>	<ul style="list-style-type: none"><li>• Иргэн</li><li>• Төрийн албан хаагч</li><li>• Орон нутгийн удирдлагын байгууллага</li><li>• Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоот хуулийн этгээд,</li><li>• Төрийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа этгээд</li></ul>
<b>Цахим бүтээгдэхүүний агуулга, хэлбэр</b>	<ul style="list-style-type: none"><li>• эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төр ёсны үзлийг дээдлэх, үнэт зүйл бүхий хандлагыг төлөвшүүлэх,</li><li>• төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн сэтгэл зүйд эергээр нөлөөлөх,</li><li>• Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.1, 8.1, 8.2 дэх заалт болон Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-ний хүрээнд агуулга гаргах,</li><li>• Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн 3.2, 4.1.1-тэй уялдсан байх;</li></ul> <p><b>Цахим бүтээгдэхүүн:</b></p> <ul style="list-style-type: none"><li>• 1.5-3 минутын хөдөлгөөнт тайлбар видео 3 ширхэг;</li><li>• 30-60 секундийн богино видео контент 6 ширхэг;</li><li>• инфографик, сэдэвчилсэн /carousel/ постер 5 багц;</li><li>• нийгмийн сүлжээнд түгээх цахим постер 15 ширхэг;</li><li>• бүтээгдэхүүн тус бүрийн гарчиг, тайлбар, нийтлэлийн текст;</li><li>• 1-3 сарын түгээлтийн календарь, үр дүнгийн тайлангийн загвар.</li></ul>

<p><b>Гүйцэтгэгчид тавих шаардлага</b></p>	<p>Хүний нөөц: 1. Найруулагч-1, График дизайнер буюу мульти-медиа-1 байна. Шаардлага: - Мэргэжлийн дипломын хуулбар - Мэргэжлээрээ 2 ба түүнээс дээш жил ажилласан - Салбартаа 2-оос дээш жил үйл ажиллагаа явуулсан байх - Контент үйлдвэрлэлийн туршлагатай - Анимейшн, жүжигчилсэн контент хийх чадвартай - Сошиал түгээлтийн туршлагатай - Хууль сурталчлах хүрээнд төрийн байгууллагатай хамтран ажилласан жагсаалт. - Байгууллагын гэрчилгээний хуулбар - Үндсэн болон мэргэжлийн тоног төхөөрөмжтэй байх,</p>
<p><b>Гүйцэтгэх ажлын төлөвлөгөө</b></p>	<p>Гэрээ байгуулахдаа ажлын төлөвлөгөө, хуваарь боловсруулж, захиалагч талд танилцуулж батлуулна. - Үндсэн санаа, үзэл баримтлал боловсруулах: 1 хоног - График дизайн/анимейшн: 10 хоног - Эвлүүлэг, пост продакшн: 3 хоног Нийт хугацаа: 14 хоног</p>
<p><b>Санхүүжилт, гэрээ</b></p>	<p>Гэрээ байгуулах хэлбэр: Шууд гэрээ Санхүүжилтийн хэмжээ: 20 сая хүртэл</p>
<p><b>Тайлангийн хуваарь</b></p>	<p>Ёс зүйн хорооны Ажлын албатай нягт хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа Ажлын албаны даргад тайлагнаж ажиллана. Ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж актаар хүлээлгэж өгнө.</p>
<p><b>Тайланд тавигдах шаардлага</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• гүйцэтгэсэн ажлын жагсаалт, хугацаа, хариуцсан ажилтан, гарсан үр дүнг тодорхой тусгасан байх;</li> <li>• бүтээгдэхүүн бүрийн зорилго, зорилтот бүлэг, гол мессеж, ашиглах сувгийг тайлбарласан байх;</li> <li>• цахим түгээлтийн үзүүлэлт, хандалт, үзэлт, хуваалцалт, санал сэтгэгдлийн нэгтгэлтэй байх;</li> <li>• цаашид дахин ашиглах, шинэчлэх, байгууллагуудад түгээх санал, зөвлөмжтэй байх;</li> <li>• бүх эх файл, засварлах боломжтой файл, эцсийн экспорт хувилбарыг хавсаргасан байх.</li> </ul>
<p><b>Хүлээгдэж буй үр дүн, бүтээгдэхүүн</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, нийтлэг шаардлага, хориглох зүйл, хариуцлагатай харилцаа, иргэн төвтэй үйлчилгээний талаарх ойлголт олон нийтэд энгийн, ойлгомжтой хэлбэрээр хүрнэ.</li> <li>• Иргэдтэй харилцах эерэг хандлага, ёс зүйтэй үйлчилгээний соёл, хүний нэр төрийг хүндэтгэх дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн цахим бүтээгдэхүүний нэгдсэн багц бүрдэнэ.</li> <li>• Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороо, төрийн байгууллагууд сургалт, зөвлөгөөн, дотоод нөлөөллийн ажилдаа ашиглах боломжтой стандарт мессеж, контенттой болно.</li> <li>• Төрийн албан хаагч нийгэмд зөв харагдах харилцаа, хандлага, хариуцлагатай зан үйлээр үлгэрлэх тухай эерэг хандлага нэмэгдэнэ.</li> <li>• Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүртээмж, давтамж, үр нөлөө нэмэгдэнэ.</li> <li>• Бүтээгдэхүүнийг сургалт, олон нийтийн нөлөөллийн ажил, байгууллагын дотоод соёлын өдөрлөг, зөвлөгөөнд давтан ашиглах боломж бүрдэнэ.</li> </ul>
<p><b>Байршил, хугацаа:</b></p>	<p>Улаанбаатар хот, хугацаа 14 хоног.</p>